



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 170

Улаанбаатар хот

“МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн
2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот
түвшин болон Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн
гэрээний биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Гүйцэтгэх захирал Б.Мөнхтамиртай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2. “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Б.Мөнхтамиртай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж болгосугай.

3. “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлж, 2023 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт “Сайн” гэж дүгнэгдсэн тул Гүйцэтгэх захирал Б.Мөнхтамирт хавсралтад заасны дагуу урамшуулал олгосугай.

4. Гүйцэтгэх захирал Б.Мөнхтамирт хавсралтын дагуу олгох урамшууллыг холбогдох эх үүсвэрээс гаргахыг “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн Ерөнхий нягтлан бодогч Д.Мөнхтулгад зөвшөөрсүгэй.

5. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132061308

11-r huraldaan.docx